

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255002>

МОНГОЛ ХЭЛНИЙ НЭР ҮГИЙН ОРХИЛ: ТОДОТГОЛЫН ОРХИЛ

Г.Баттогтох
Л.Лхагвасүрэн

Түлхүүр үг: Тогтолцоот үүргийн хэл шинжлэл, холбоосжилт, орхил, нэр үгийн орхил

Удиртгал

Орхил (ellipsis) бол *Тогтолцоот үүргийн хэл зүй (TYX)* буюу *Systemic Functional Grammar (SFG)* онол дахь холбоосжилтын нэг төрөл бөгөөд үүнийг онолын түвшинд цогц хэлбэрээр тодорхойлж хөгжүүлсэн хэл шинжлэлч нь М.А.К.Халлидэй (M.A.K.Halliday), Рукайяа Хасан (Ruqaiya Hasan) нар юм. Тэдний “*Англи хэлний холбоосжилт*” (*Cohesion in English, 1976*) бүтээлд орхилыг *тэг орлол* гэж үзсэн нь хэл шинжлэлд онолын шинэ чиг баримжаа болж хөгжжээ. Тус бүтээлд орхил бол аливаа бичвэрт холбоосжилт болох, давтагдсан мэдээллийг орхих байдлаар утгын уялдааг бий болгох, уншигч-харилцагчийн өгүүлэн буй мэдээлэл, түүний дарааллыг сэргээн санах чадварт суурилсан хэлний стратеги гэж тодорхойлсон байна.

М.А.К.Халлидэй болон К.М.И.М.Маттиссен (Christian M.I.M.Matthiessen) нар “*Халлидэйн Үүргийн хэл зүйн удиртгал*” (*Halliday's Introduction to Functional Grammar, 1994, 2004, 2014*) бүтээлдээ орхилын үгийн сан, хэл зүйн тогтолцоо дахь байр, утга, үүргийг нарийвчлан судалжээ. Эдгээр бүтээл нь *өгүүлбэр*, *хэллэг*-т орхил хэрхэн илрэх, ямар нөхцөлд нэгж, санаа сэргээгдсэн гэж үзэх зэрэг асуудлыг судлан тогтоож, задлан тайлбарласан юм. Түүнчлэн орхилыг бичвэрийн метафункцын бүрэлдэхүүн гэж үзэн өгүүлбэрийн утга, хам сэдэв, регистр, төрөл зэрэг хүрээнд нөхцөлддөг нэгэн төрлийн хэлний сонголт гэдгийг онцолсон юм.

Сюзан Эггинс (Suzanne Eggsins) “*Тогтолцоот үүргийн хэл шинжлэлийн удиртгал*” (*An Introduction to Systemic Functional Linguistics, 2004*) бүтээлдээ орхилыг ТҮХШ-д заах арга, эх судлалд хэрхэн ашиглах тухай тайлбарлажээ. Тэрээр орхилын төрөл: *нэр үгийн орхил*, *үйл үгийн орхил*, *өгүүлбэрийн орхил* (nominal, verbal, clausal ellipsis)-ыг жишээгээр тайлбарлаж, орхил нь бичвэрийн утга санааны тодорхой, ойлгомжтой байдал хийгээд уншигчийн анхаарал, мэдээлэл боловсруулах үйл явцад хэрхэн нөлөөлдгийг шинжилж үзсэн юм. Жефф Томпсон (Geoff Thompson) “*Үүргийн хэл зүйн удиртгал*” (*Introducing Functional Grammar, 2014*) бүтээлдээ орхилыг мэдээллийн бүтэцтэй холбон тайлбарлаж, өгөгдсөн мэдээлэл, шинэ мэдээллийн бүтэцэд голлох үүрэгтэй болохыг шинжлэн өгүүлжээ. Ж.Р.Мартин (J.R.Martin) “*Англи хэлний эх: Тогтолцоо ба бүтэц*” (*English Text: System and Structure, 1992*) бүтээлдээ орхилыг бичвэрийн бүтцийн түлхүүр,

нөөцийн нэг гэж үзсэн ба өгүүлсэн санааны бүтцийг давталгүйгээр үргэлжлүүлэх төлөвлөлт гэж тайлбарлажээ. Тухайлбал, дэвсвэр, онцолбор мэдээллийн бүтцийн хүрээнд орхилын үүргийг тодруулсан байдаг бөгөөд орхил нь өгүүлбэрийн онцолборыг тодорхой болгож, дэвсвэр мэдээлэлд өгүүлэх мэдээллийг дарааллаар нь цэгцтэй илэрхийлэхэд голлон нөлөөлнө гэж үзсэн юм. Margaret Berry (Margaret Berry)-гийн “Өгүүлбэр солилцооны нэгж болох нь” (*Clause as Exchange*, 2012) зэрэг бүтээлд орхилыг *харилцах метафункц (interpersonal metafunction)*-тэй холбон тайлбарласан нь Тогтолцоот үүргийн хэл шинжлэл онолын олон түвшинд харгалзан үздэг, суурь чиглэлийг баяжуулсан судалгаа болсон байна.

М.А.К.Халлидэй, Рукайяа Хасан нар *Тогтолцоот үүргийн хэл шинжлэл* онолын хүрээнд “Орхил гэдэг нь бүтцийн хувьд зайлшгүй шаардлагатай нэгж орхигдсон боловч утга санаа нь ойлгогдож байдаг холбоосжилт”, “орхил нь зөвхөн орхих үйлдэл биш, тодорхой нөхцөлд хасагдаж байгаа үйлдэл”, “орхигдсон зүйл нь тухайн нөхцөл байдлаас нөхөгдөх боломжтой” (1976: 142-145) гэж үзжээ. Энэхүү үзэл нь *орхил*-ыг төгс санааны бүрэлдэхүүнээс зориуд хасаж буй үйлдэл биш, харин аливаа төгс санааны утгыг төгөлдөржүүлэх явц, сонголт гэж тайлбарлах үндэслэл болно. Тэд *орхил*-ыг *нэр үгийн орхил*, *үйл үгийн орхил*, *өгүүлбэрийн орхил* гэж 3 үндсэн бүлэгт хувааж, улмаар дэд бүлэг бүрийг хэд хэдэн хэсэгт ангилан судалсан нь холбоосжилтын анхны тогтолцоот судалгаа болсон юм. Тодруулбал, 1. *Нэр үгийн бүлгийн орхил*-ыг нэр үгийн бүлгийн дотор тодорхой нэр үг, эсвэл бусад дэлгэрүүлэгч бүрэлдэхүүн орхигдсон тохиолдол; 2. *Үйл үгийн бүлгийн орхил*-ыг үйл үгийн бүлэгт үйл үгийн үндсэн хэлбэр, эсвэл зарим туслах үйл үг орхигдсон тохиолдол; 3. *Өгүүлбэрийн орхил*-ыг бүхэл өгүүлбэрийн дотор нэг бүрэлдэхүүн, эсвэл хэд хэдэн бүрэлдэхүүн (өгүүлэгдэхүүн, шууд тусагдахуун гэх мэт) орхигдсон тохиолдол (1976: 143-145) гэж нарийвчлан ангилж судалсан байна. “Англи хэлний холбоосжилт” бүтээлд дэвшүүлсэн уг санал, загвар холбоосжилтын судалгааны онолын үндэс болдог бөгөөд хэл шинжлэлчид энэхүү онол, ангилал, загварыг баримтлан олон хэлний холбоосжилтыг судлан шинжилж, тайлан тайлбарласан байна.

М.А.К.Халлидэй, К.М.И.М.Маттиссен нар “Орхил бол тэг орлолын нэг төрөл юм” (2014: 614) гэж үзсэн байх бөгөөд аливаа өгүүлбэрт орлох нэгж байхгүй мэт боловч өгүүлбэрийн бүтэц түүнийг зайлшгүй шаарддаг гэжээ. Тэд орхилыг харилцаа ярианд “өмнө өгүүлсэн зүйлээс бүтцээр урьдчилан таамаглах боломжтой нөхцөлд давтахаас зайлсхийх зорилгоор ашиглах нэгэн төрлийн нөөц” (2014: 616) гэж тодорхойлсон юм. Мөн “орхил нь зөвхөн орхих үзэгдэл биш, хэл зүйн тогтолцоо дахь нэгэн төрлийн сонголт” (2014: 618) болохыг тэмдэглэсэн байна. Тиймээс орхил гэдэг бол өгүүлэх санааны зорилгод нийцүүлэн хэсэг нэгжийг орхих байдлаар өгүүлбэр, цогцолбор, эхийг хувиргаж буй арга болно. Ертөнцийн юм үзэгдэл тоо томшгүй, харин хүн тэрхүү юм үзэгдлийг танин мэдэх, илэрхийлэн харилцах хүрээ хязгаартай байна. Хязгааргүй юм үзэгдлийг хязгаарт багтааж илэрхийлэхэд орхил гол хэрэглүүр болно. Хэсэглэн өгүүлэх төгс санаа буюу өгүүлбэр бүрд харьцангуй орхил орших тул орхилгүй өгүүлбэр, өгүүлбэргүй орхил гэж үгүй хэмээн хэлж болох юм. Юм үзэгдэл өгүүлбэрт багтаж, өгүүлбэр орхилыг багтаана.

Сюзан Эггинс “Тогтолцоот үүргийн хэл шинжлэлийн үүднээс орхил гэдэг нь тухайн хэлний орчноос нөхөгдөх нэгжийг орхих үйлдэл” (2004: 96-97) гээд орхилыг орлолтой нягт холбоотой холбоосжилт гэж үзэж, түүнийг “тэг орлол” хэмээн нэрлэжээ. Түүний дэвшүүлсэн санаа нь М.А.К.Халлидэй нарын үзэл баримтлалтай нийцэх бөгөөд зарим ангилал, холбогдох судалгаа нь уг ухагдахууныг олон талаас

дэлгэрүүлэн тайлбарласнаараа шинэлэг болсон байна. Тэрээр энэхүү ойлголтыг харилцаа ярианы жишээгээр тайлбарлахдаа, “Сонсогч, харилцагч нь харилцааны орчинд өгүүлээгүй буюу дутуу байгаа нэгжийг нөхөж ойлгохоор байгаа тохиолдолд давталтаас зайлсхийдэг, эхийг хэмнэлттэй, товч тодорхой болгоход тусалдаг” гэсэн санааг судалгаанд тусгасан юм.

Жефф Томпсон орхилыг “Эхийн хэмнэлтийн зарчмаар буй болсон хэл зүйн сонголт” (2014: 181) гэж тодорхойлдог бөгөөд харилцаа ярианд “өгөгдсөн мэдээллийг орхисноор харилцааг түргэсгэдэг” (2014: 183), харин бичгийн хэлэнд “давталтыг багасгадаг” (2014: 184) гэж өгүүлжээ. Түүний дэвшүүлсэн санаа нь М.А.К.Халлидэй нарын онолыг бататгасан ба эхийн хэв маягаас хамаарч үүрэг нь өөр өөр байж болох тухай ажиглалтаас бүрдэж байна.

Монгол хэл шинжлэлд өгүүлбэрийн бүтэц, хэв маягийг тодорхойлох судалгаа голлодог бөгөөд эдгээр судалгаанд *холбоосжилт*, *орхилттой* холбоотой зарим ажиглалт, ангилал, тайлбар бий¹. Тухайлбал, Ш.Лувсанвандан “Үглэхүүний бүлгийн эцсийн үйл үг нь үйл үгийн цаг заах, захирах хүсэх нөхцөлөөр хэлбэржих тухай асуудалд” хэмээх өгүүлэлдээ “Ямар ч үгэлбэр нь үглэгдэхүүн, үглэхүүн гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй байна. Энэ хоёр бүрэлдэхүүн нь хоёр үгээр бүтсэн, дөрвөн үгээр бүтсэн, найман үгээр бүтсэн янз бүр байж болно. Жишээлбэл, *Багш ирлээ. Манай багш мориор ирлээ. Манай хэлний багш бор мориор ирлээ. Манай сумын хэлний багш өнөөдөр бор мориор ирлээ* гэх мэт. Үглэгдэхүүний бүлэг нь юм үзэгдлийг орлосон, үглэхүүний бүлэг нь харьцаа хөдөлгөөнийг орлосон байна. Юм үзэгдэлгүй хөдөлгөөн, хөдөлгөөнгүй юм үзэгдэл гэж байхгүй тул чанартаа юм буюу үзэгдлийг хөдөлгөөнийх нь хамт гүйцэд заасан төгс дохио болох үгэлбэр нь заавал үглэгдэхүүн, үглэхүүн гэсэн хоёр бүрэлдэхүүнээс бүтэх ёстой байна. Гэвч ярихад аль нэг бүрэлдэхүүнийг нь бүхлээр, эсвэл зарим хэсгийг нь нэг хэлбэрээр хураан хэлж болно. Жишээлбэл, *Би оюутан (байна). Тэр хүн багш (байна)* гэх мэт. Үгэлбэрийн ямар нэг гишүүнийг хязгааргүй дэлгэрүүлж болдог тул бүх гишүүнийг нь шавхан, ил хэлсэн төгс үгэлбэр гэж байхгүй, байж болох ч үгүй юм. Энэ учраас үгэлбэрийн өдий төдий гишүүнийг орхиж, жинхэнэ хэрэгтэй хэдий нь хэлнэ. Ингэж үзвэл үгэлбэрийн гишүүнийг ил гишүүн, далд гишүүн гэж хувааж

¹ Монгол хэл шинжлэлд *өрөөсгөл өгүүлбэр* (Ш.Лувсанвандан, 1939), *үгүүлбэр үг* (Ш.Лувсанвандан, 1956), *заримдаг өгүүлбэр* (Ш.Лувсанвандан, 1956; Б.Рагчаа, 1977), *төгс бус өгүүлбэр* (Ш.Лувсанвандан, 1966), *гүйцэд бус өгүүлбэр* (Ш.Лувсанвандан, 1966), *дутмаг өгүүлбэр* (Ш.Лувсанвандан, 1978), *тогтворгүй, нэг бүрэлдэхүүнт, бүрэн бус өгүүлбэр* (М.Базаррагчаа, 1986), *бүрэн бус өгүүлбэр* (Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, З.Гулираанз нар, 1995), *сул үг-өгүүлбэр* (Б.Пүрэв-Очир, 1997), *өгүүлбэр үг* (Ш.Лувсанвандан, Б.Рагчаа, Т.А.Бертагаев, Л.Дамдинжав, Ц.Жанчивдорж), *үгэн өгүүлбэр* (Ш.Барайшир), *ганц үгт өгүүлбэр* (Даваадагва нар), *орхилт* (Г.Баттогтох, 2023) гэдэг нэр томъёо бүхий ойлголтын хүрээнд орхилыг судалж иржээ. Жишээлбэл, Ш.Лувсанвандан “Угтаа үгүүлэгдэхүүн, үгүүлэхүүн хоёргүй үгүүлбэр гэж байхгүй. Гэвч хааяа хэлж байгаа, хэлэлцэж байгаа хүмүүсийн санаанд энэ хоёр чухал гишүүдийн аль нэгийг буюу хааяа хоёуланг санаандаа бодоод амандаа хэлэхгүй орхих зүйл бий. Ийм байдалтай үгүүлбэрийг *өрөөсгөл үгүүлбэр* гэнэ. Хэрвээ үгүүлэгдэхүүн үгүүлэхүүн хоёр гол гишүүд илэрхий гарч ирсэн үгүүлбэрийг *гүйцэд үгүүлбэр* гэнэ. Жишээлбээс, *Чи хэзээ ирсэн бэ? – Би уржигдар ирэв. Одоо хаа очно? – Сургууль дээр очно. Таны нэр хэн бэ? – Самбуу.* Үүнд: нэгдүгээр үгүүлбэр үгүүлэгдэхүүн үгүүлэхүүн хоёр илэрхий гарч ирсэн гүйцэд үгүүлбэр, хоёрдугаар нь мөн гүйцэд үгүүлбэр, гуравдугаар нь гагцхан үгүүлэхүүн бүхий тул өрөөсгөл үгүүлбэр, дөрөвдүгээр нь мөн өрөөсгөл үгүүлбэр, тавдугаар нь гүйцэд үгүүлбэр, зургаадугаар нь үгүүлэгдэхүүнгүй тул *өрөөсгөл үгүүлбэр* болно” (1939, 44-51/ 2010, VII: 157) гэж тайлбарласан нь тодорхойлох байдал, үндсэн шинжээрээ *орхил*-ын тухай орчин үеийн хэл шинжлэлийн судалгаатай дүйж байгаа юм.

болно. Далд гишүүд гэсэн нь хэлээгүй орхисон гишүүд² болно. Хэрэв хамаг юм үзэгдэл шүтэн барилдаж бас хязгааргүй байдаг бол тэр бүгдийг багтаасан төгс үгэлбэр гэж байж болохгүй байна. Энэ далд гишүүн нь бүхэл үглэгдэхүүний бүлэг, үглэхүүний бүлэг, үглэгдэхүүн, үглэхүүн зарим хэсэг ч байж болно. Өөрөөр хэлбэл, далд гишүүнгүй үгэлбэр байж болохгүй юм (1978: 45-58/ 2010, 7: 296)” гэж бичсэн байна. Энэхүү өгүүлэлд юм үзэгдэл болох анхдагч дохио буюу хэлний гүн бүтэц, юм үзэгдлийг орлосон хоёрдогч дохио буюу хэлний өнгөн бүтцийн мөн чанар, харилцах хүрээ-өнгөн бүтцийн хязгаарлагдмал байдлын талаар өгүүлжээ. Үүнээс улбаалуулан *орхил* бол өнгөн бүтцийн мөн чанарыг илэрхийлэх хэрэглүүр, харилцааг тодорхойлох хүрээ гэж хэлж болно.

Ш.Лувсанвандан “Салангид үгийн утгатай, үгийн хэл зүйн утга хослох тухай асуудалд” өгүүлэлдээ “Үгэлбэр нь юм үзэгдлийг хөдөлгөөний хамт заасан дохио байдаг тул харьцангуй утга төгссөн байна. Үгэлбэр нь заавал үглэгдэхүүн, үглэхүүний хоёр бүрэлдэхүүнээс бүрэлдсэн байна” (2010, 7:304/ 1978: 36-39), “Үгэлбэрийн бүрэлдэхүүн нь нэг нэг үгээр, хоёр хоёр үгээр, дөрөв дөрвөн үгээр ч байж болно. Үгэлбэрийн гишүүд нь ил, далд хоёр янз байж, мэдэхэд хэрэгтэй гишүүн нь ил байна. Үгэлбэр нь хязгааргүй бодит ертөнцийн нэг өчүүхэн тасархайн дохио тул үгэлбэрийн гишүүдийг асуултаар нэмэн дэлгэрүүлэхэд хязгаар байдаггүй. Жишээлбэл, *Багш ирлээ. Ямар багш юугаар ирэв? Манай багш мориор ирлээ. Танай ямар багш ямар мориор ирэв? Манай хэлний багш бор мориор ирлээ* гэх мэт. Заримдаа үглэгдэхүүний бүхэл бүлэг, үглэхүүний цөмийг ч орхиж, далд байж болно. Жишээлбэл, *Чи хөдөөнөөс юугаар ирэв?* гэхэд зөвхөн *мориор* гэж хариулж болно. Энэ нь *Би хөдөөнөөс мориор ирлээ* гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй үгэлбэр болно” (2010, 7:306-307/ 1978: 36-69) гэжээ. Ташрамд, Ш.Лувсанвандан монгол хэл шинжлэлд үгэлбэрийн зарим хэсгийг хурааж хэлэх тухай өгүүлж, улмаар уг зүй тогтлыг *орхисон гишүүд, үглэгдэхүүний бүхэл бүлэг, үглэхүүний цөмийг орхиж, далд байлгаж болно* гэх зэргээр томъёолон тайлбарласан нь бидний энэхүү судалгааны үүдэл санаа, *ellipsis* гэдэг ойлголтыг *орхил* гэж оноох үндэслэл болсон юм.

М.Базаррагчаа нар “Монгол хэлэнд өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийн хэл зүйн хэлбэрүүдийг хурааж эцсийн гишүүнд нь илрүүлдэг шиг, өгүүлбэрийн мэдэгдэж буй тодорхой гишүүнийг болон давтагдан хэлэгдэх гишүүнийг хураан хэлэх

² Ш.Лувсанвандан “Заримдаа гишүүн үгүүлбэр нь үгүүлэгдэхүүнгүй байж болно. Жишээлбэл, *Хөдөөнөөс морь авчирсан хүн ирэв. Маргааш орой гурван цагт манай сургууль дээр хуралтайг та нар мэдсэн үү? Машинаар хадсан өвсийг хураав* гэх мэтчилэн. Үүнд гишүүн үгүүлбэрээр тодруулсан үг нь утгаараа уул гишүүн үгүүлбэрийн үгүүлэхүүнээр илэрсэн үйл байдлын эзэн байвал уул гишүүн үгүүлбэр нь үгүүлэгдэхүүнгүй байна. Жишээлбэл, *Адуун дээрээс морь авчирсан хүн ирэв* гэх мэт. Бас уул гишүүн үгүүлбэр нь нэгэн бүрэлдэхүүнт үгүүлбэр байвал мэдээжийн хэрэг тусгайлан үгүүлэгдэхүүнгүй байна. Жишээлбэл, *Манай сургууль дээр маргааш хуралтайг мэдсэн үү?* гэх мэт. Мөн хойдох урдах үгээс буюу орчны байдлаас утга нь тодорхой байвал зохих гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүнийг орхисон байж болно. *Уулнаас морин дээр авчирсан түлээг хашаанд хураав* гэх мэт. Бас гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүн нь хойноо гурван биеийн аль нэгийг заасан *минь, чинь* гэж хамаатуулах үгтэй байвал уул гишүүн үгүүлбэрийн үгүүлэхүүнээр илэрсэн үйл байдлын эзэн нь тодорхой болж ирэх тул ийм гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүнийг заримдаа орхиж болно. Жишээлбэл, *Морио авчирсны нь би мэдсэнгүй (Батыг морио авчирсны нь би мэдсэнгүй)*” гэх мэт (1957, 6-14/ 2010, VII: 215).

тогтолцоо бий болсон байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, хүн бүрд тодорхой мэдэгдэж байгаа болон давтан хэлэх хэл зүйн хэлбэр болон өгүүлбэрийн гишүүнийг монгол хүн хэлэндээ заавал хэлэхгүй, тэг хэлбэр болон тэг хувилбараар хэлэх хэлний хэмнэлтийн зарчмыг бий болгожээ. Жишээ нь: (1) *Бид Архангай, Увс, Ховдоор яваад ирлээ.* (2) *Та үүнийг ойлгов уу? – Ойлголоо.* (3) *Дорж хөгжим тоглож, дуу дуулав.* (4) *Дорж хөгжим тоглонгоо дуу дуулав* гэх мэт. Үүнээс үзвэл (1) өгүүлбэрт эцсийн бус, зэрэгцсэн гишүүдийн хэл зүйн хэлбэрийг хурааж зөвхөн эцсийн гишүүнд нь илрүүлжээ. Хэрэв мэдэгдлийн нэгж бүрийг чухалчилбал *Бид Архангайгаар, Увсаар, Ховдоор яваад ирлээ* гэж хэлэх тогтолцоо монгол хэлэнд байдаг ажээ. Түүгээр үл барам тухайн өгүүлбэрт *аймаг* гэх тодорхой гишүүнийг хураан хэлсэн байна. Хэл зүйн ийм үзэгдлийг *бүтээврийн тэг хувилбар* гэдэг. Иймд (1) дэх өгүүлбэрийн хэл зүйн тэг хувилбар шиг (2) *Та үүнийг ойлгов уу? – Ойлголоо* гэх өгүүлбэрт харилцагч нарт мэдэгдэж буй өгүүлбэрийн гишүүнийг хураан хэлжээ. Хэрэв бид мэдэгдлийн нэгж бүрийг чухалчилбал *Та үүнийг ойлгов уу? – Би ойлголоо* гэж хураахгүй хэлдэг байна. Иймд (1) өгүүлбэрт илээр илрээгүй аймаг гэх гишүүнийг *өгүүлбэрийн тэг гишүүн* гэж бид ойлгож болох бол, (2) өгүүлбэрийн давтагдах тохиолдолд хураан хэлсэн *би* гишүүнийг тэг хувилбар гишүүн хэмээн ойлгож болно” (2022: 187) гэж тайлбарласан байна. Энэхүү судалгаанд *өгүүлбэрийн тэг гишүүн, тэг хувилбар гишүүн* зэрэг нэршлийг үүсгэн бичсэн нь орхилын ерөнхий шинжид холбогдоно. “Өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн болон өгүүлэхүүний бүлэг нь хоёулаа байвал хоёр бүрэлдэхүүнт, нэг нь байвал нэг бүрэлдэхүүнт өгүүлбэр гэнэ. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг бүтээж буй өгүүлбэрүүд нь энгийн өгүүлбэр шиг 2 бүрэлдэхүүнт ба 2 бүрэлдэхүүнт, 2 бүрэлдэхүүнт ба 1 бүрэлдэхүүнт, 1 бүрэлдэхүүнт ба 1 бүрэлдэхүүнт, 1 бүрэлдэхүүнт ба 2 бүрэлдэхүүнт байж болно. Жишээ нь: 1. 2 бүрэлдэхүүнт ба 2 бүрэлдэхүүнт: Хонх дуугарч, хичээл эхлэв. Саран мандаж, алсад адуу янцгаана. Хүн бүр баярлаж, би бүр их баярлав. 2. 2 бүрэлдэхүүнт ба 1 бүрэлдэхүүнт: Үг нь хатуу ч үйл явдалд тустай. 3. 1 бүрэлдэхүүнт ба 2 бүрэлдэхүүнт: Байшингийн дотор зул ба дэнгүй, гагцхүү зуухны доторх цурмын гэрэл сүүмэлзэнэ. 4. 1 бүрэлдэхүүнт ба 1 бүрэлдэхүүнт: Эрлийг сургаар олдог, эрдмийг хичээлээр олдог (Ардын аман зохиол). Бага идсэн ч өмхий, их идсэн ч өмхий (Аман зохиол). Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар, монголын сайхан оронд жил жил дэлгэр (Д.Нацагдорж). Байдал зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар (Ц.Дамдинсүрэн) гэх мэт” (2022: 192) гэжээ. Энэхүү бүрэлдэхүүний тухай санал нь монгол хэлний өгүүлбэр судлалд өгүүлбэрийг бүтэц, хэв шинжээр нь энгийн өгүүлбэр, нийлмэл өгүүлбэр гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилж, лавшруулаад энгийн өгүүлбэрийг аль нэгэн гишүүнийг нь хэлэхгүй орхидог байдлаас үүдэж, нэг бүрэлдэхүүнт болон хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэр гэж судалж ирсэн уламжлалыг илтгэнэ.

Монгол хэлний өгүүлбэр судлалд өгүүлбэрийн орхил, түүний төрөл зүйлийг нарийвчлан судлах нь бүтэц, хэв шинжийн судалгааны хүрээг өөрчлөн өргөжүүлэх, онол-хэрэглээг хослуулсан шинэлэг судалгааны арга зүй нэвтрүүлэх, монгол хэлний зүй тогтлыг тодруулан тайлбарлах ач холбогдолтой болно.

Нэр үгийн орхил. М.А.К.Халлидэй, Рукайя Хасан нар “Нэр үгийн бүлгийн орхил гэдэг нь тухайн бүлгийн гол хэсэг орхигдсон боловч түүний утга нь уул эхээс сэргээгдэж болох нөхцөлийг хэлнэ. Үлдэж хоцорсон бүрэлдэхүүн гишүүлбэр: тооны нэр, тэмдэг нэр нь тухайн санааг хадгалж, орхисон нэрийг нөхөх, сэргээх боломжийг бүрдүүлдэг” (1976: 146-147) гэжээ. Өөрөөр хэлбэл, хам бичвэрт үлдсэн нэгжүүд орхисон нэгжийг багтааж, утгыг нь илэрхийлнэ. *Би улааныг авна [дээл]*

гэхэд дээл гэдэг нэр үг орхигдсон байх боловч өмнөх эхээс нөхөж ойлгож болно. ТҮХШ-д нэр үгийн бүлгийн орхил-ыг нэр үгийн орхил (*Би хээрийг унана [морь]*), тооны нэрийн орхил (*Би арван ном авсан, харин тэр хоёрыг авна лээ [ном]*), тодотголын орхил (*Би хөх цамц авна, та улааныг аваарай [цамц]*) гэж ангилах нь бий.

Хэл шинжлэлчид М.А.К.Халлидэй, Рукайяа Хасан нарын холбоосжилтын онолд тулгуурлан, нэрийн орхилыг хэрэглээний талаас нь дэлгэрүүлэн тайлбарласан байдаг. К.М.И.М.Маттиссен нар (2004, 2014) нэр үгийг хэлний бүтцийн гол бүрэлдэхүүн гэж үздэг бөгөөд орхил буй болоход энэхүү гол үг нь байхгүй боловч үлдсэн нэгж нь уншигч, сонсогчийн оюун санаанд тухайн нэрийн дүр төрхийг сэргээдэг гэж үзжээ. Монгол хэл шинжлэлд Ш.Лувсанвандан “Үглэхүүний бүлгийн эцсийн үг нь үйл үгийн цаг заах, захирах хүсэх нөхцөлөөр хэлбэржих тухай асуудалд” өгүүлэлдээ “Үгэлбэр, түүний бүрэлдэхүүн нь хэчнээн олон үгээр бүтсэн ч хос хосоороо нийлсээр нэг бүхэл цогц болно. Энэ учраас үгэлбэр нь нэг бүхэл цогц байвч хоёр бүрэлдэхүүн-үглэгдэхүүн, үглэхүүнтэй байна. Хоёр бүрэлдэхүүн хоёр хоёр дөрөв, тэр дөрөв нь хоёр хоёр найман бүрэлдэхүүнтэй байх мэт. Эдгээр бүрэлдэхүүн гишүүнийг өдүй төдүй нь далд байна. Үгэлбэрийн ил гишүүнийг мэдэхэд далд гишүүнийг бас мэдэх хэрэгтэй. Тэр далд гишүүд харьцаагаараа мэдэгдэнэ (1978: 45-58/ 2010, 7: 299)” гэж өгүүлсэн нь өгүүлбэрийн өгүүлээгүй орхисон гишүүн-нэгж буюу орхил гэдэг ойлголттой тохирч байгаа юм.

Сюзан Эггинс “Өгүүлэн буй юм үзэгдлийн хэн, юу болох, ямар утгатайг өмнөх хам бичвэрээс сэргээх шаардлагатай болдог. Энэ нь хэлэгч, бичээчдэд давталтаас зайлсхийж, ойлгомжтой байдлыг хадгалах боломж олгодог” (2004: 98-99) гэсэн нь дээрх онол, саналтай шууд тохирно. Жефф Томпсон “Нэр үгийн бүлгийн орхил гэдэг нь нэр үгийн бүлэг нэр үггүй боловч бусад нэгж нь гол утга санааг нөхөн илрүүлэх боломжтой байхыг хэлнэ (2014: 183-184)” гээд орхилын хэрэглээг зөвхөн холбоосжилт гэхээс илүү тухайн өгүүлбэрийн мэдээллийн бүтэцтэй холбон тайлбарлажээ.

К.М.И.М.Маттиссен нар “Нэр үгийн бүлгийн орхилын үед нэр үгийн бүлгийн тодотгогч бүтвэр нь нэрийн гүйцэтгэдэг үүргийг өөртөө авдаг. Орхисон нэр үг нь өмнөх ярианы хэсэг, эсвэл нөхцөл байдлын агуулгаас сэргээгдэж болно” (2010: 105-106) гэжээ. Тэдний тайлбар нь орхилыг харилцааны нөхцөл байдлаас сэргээх боломжтойг онцолдогт оршино.

Энэхүү суурь судалгааг лавшруулж, хөгжүүлсэн хэл шинжлэлчид дараах байдлаар шинэ ангилал, санал дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Гол нэр үгийн орхил. Гол нэр үг (*юм, үзэгдэл*)-ийг орхих, утга нь нөхцөл байдлаас сэргээгдэх хэлбэр. Жишээ нь: *Би улаан дээл авна, харин тэр цэнхрийг (-) авна (“дээл” орхигдсон).*

2. Ангиллын орхил. Төрөл, ангиллыг илэрхийлэх үг орхигдоно. Жишээ нь: *Би ноосон цамцанд дуртай, торгон (-) биш (“цамц” орхигдсон).*

3. Хамаатуулах бүтцийн орхил. Хамаатуулах бүтэц (*энэ жилийнх, манай нутгийнх* гэх мэт) доторх нэр үгийг орхино. Жишээ нь: *Манай байр том, тэднийх (-) жижиг (“байр” орхигдсон).*

4. Орлолоор илрэх орхил. Орхилыг орлох үг ашиглан илэрхийлдэг. Жишээ нь: *Тэр улааныг авсан, би ийм Ө-ийг авна (нэр орхигдсон, “ийм” нь орлол).*

Нэр үгийн бүлгийн эдгээр орхилын төрлөөс нэр үгийн орхил, тодотголын орхил ба ангилал үгийн орхилыг жишээ, задлал, тайлбар бүхий хүснэгтээр үзүүлэв.

Д/д	Орхилын төрөл	Жишээ	ГҮХШ бүтцийн задлал	Орхисон хэсэг	Тайлбар
1	Нэр үгийн орхил	Эдгээр гутал үнэтэй, харин тэр (-) хямдхан.	Нэр үг: гутал (Юм үзэгдэл): → Нэр үг: тэр [гутал]	гутал	“Гутал” гэдэг үг өмнө нь дурдагдсан тул орхисон ба “тэр” төлөөний үг нь утгыг хадгалж байна.
2	Тодотголын орхил/ Ангиллын орхил	Залуу багш зарчимч, ахмад нь энэрэнгүй.	Нэр үг: багш (Юм үзэгдэл): → Нэр үг: ахмад [багш]	багш	“Ахмад” гэдэг тодотгол гишүүн “багш” гэдэг үгийг орлож байна.

Нэр бүлгийн орхил, түүний жишээ, тайлбар

Тодотголын орхил. М.А.К.Халлидэй (2004) “Хэл нь юм, үзэгдлийг зөвхөн нэрлээд зогсохгүй, үнэлж, ангилж, өнгө аясыг нь тодруулдаг” гэж өгүүлсэн нь тодотголын утга зүйн үүрэгтэй холбогдоно. Тодотгол гишүүлбэр нь чөлөөт бус найруулгатай эхэд өргөн хэрэглэгддэг, тодорхой нэгэн нэр үгийн буюу юм үзэгдлийн шинж, чанар, үнэлэмжийг онцлон илтгэдэг үг юм. Тодруулбал, тодотгол гишүүлбэр бол тухайн нэрлэгдсэн юм, үзэгдлийн хэрхэн үзэгдэх, ямар сэтгэгдэл төрүүлэх, яаж үнэлэгдэх талаас нь нэмэлт утга агуулга бий болгоно. Учир нь аливаа юм үзэгдэл хөдөлгөөнөөс ангид оршдоггүй тул дотооддоо ямагт шинж, байдал, үнэлэмж агуулж байна. Уг шинж, байдал, үнэлэмжийг хүн бүр өөр өөрийн танин мэдэхүйн хүрээнд ухаарч, өөр өөр хэлбэрээр буюу хэлний өнгөн бүтцээр илэрхийлнэ. Жишээ нь: “алтан намар”, “уужим тал”, “хөх тэнгэр”, “сайхан хүн”, “саруул ухаан” гэх мэт тодотгол нь тухайн юм үзэгдлийн шинж чанарыг тодруулж, сонсогч, уншигчийн төсөөллийг бүрдүүлдэг юм.

Тодотголын үүргийг тэмдэг нэр голлон гүйцэтгэнэ. “Монгол хэлний тэмдэг нэр нь жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолдож, тэдгээрээр тэмдэглэгдэж байгаа хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг нэрлэх үл хувилах үг юм. Жишээлбэл, *хурдан, удаан, сайн, муу, тарган, туранхай, хар, цагаан, хул, шарга, гонзгой, цандгар, бөндгөр, толигор, арзгар, өргөн, нарийн, зоригтой, зориггүй* гэх мэт. Тэмдэг нэрээр тэмдэглэгдэж байгаа чанар шинж бодит ертөнцийн юмс үзэгдлээс салангид байдаггүй” (Ц.Өнөрбаян, 2004: 227). Тодотгол буюу тэмдэг нэр нь ямар нэгэн юм, үзэгдлийг ердийн нэршлээс нь илүү урнаар илэрхийлж, хүний сэтгэлийг хөдөлгөх байдлаар өгүүлэх зориулалттай хэлний хэрэглүүр юм.

Хэл шинжлэлийн хувьд тодотгол нь хэрэглээний болон утга зүйн түвшний үзэгдэл болно. Хэрэглээний хувьд өгүүлэгчийн хандлага, үнэлэмжийг илэрхийлэх бол утга зүйн хувьд нэмэлт холбох утга агуулж, нэр үгийн утгыг баяжуулна. Уран зохиолын эхэд тодотгол хамгийн их хэрэглэгдэнэ. Жишээ нь: “*Сүрэнхүү үүнд сонирхох нь бага, түүнд шамдах их тул чиглэсэн зүг давхин өнгөрөх бөгөөд шувуун саарал, үдэш болтол өглөөний хэвээр хатирсаар, нарийн сайхан дөрвөн хөл нь уул ухаагийн тоосыг будруулсаар, ойр зэргэлдээ суусан нутгийн айлын хөгшид залуус түүний барааг харж гайхна. Ийм сайхан морь унасан хүн хаашаа одно гэж цөм*

ширтсээр хоцорно. Хурдлан давхих нь нэн их, хараахан нэг зуур эргэцүүлэхийн зуур далд орон, сураггүй болжээ. Түүнээс тэр хошууны нутгийн дунд орохын хамт Сүрэнхүүгийн сэтгэл их л бахтай болж, Сүнжидмаагийн гэр ойртсон гэж баярлах боловч, хуучин сар орой мандах тул, алс замын чигийг олж ядна. Цагаан гэгээ нэгэнт замхарч, үдшийн байдал бас ч хожимдсон, явах замыг гагцхүү шувуун саарал удирджээ...” (Д.Нацагдорж, Шувуун саарал).

Тодотголыг шинжээр нь дараах хэдэн зүйлд хувааж тайлбарладаг. Үүнд: *логик тодотгол* (бодит шинжийг илэрхийлсэн тодотгол: *урт зам*), *уран дүрслэлтэй тодотгол* (мөрөн голын цэнхэрхэн хөвөө), *үнэлэмжийн тодотгол* (сайхан хүн), *сэтгэл хөдлөлийн тодотгол* (урьхан хонгор салхи), уламжлалт тодотгол (аман зохиол, сонгодог зохиолд голлон давтагддаг: Эрийн сайн Хан Харангуй туульд “Алсын өндөр уулыг чиглүүлж Хавчиг жалгыг гишгүүлж Уужим жалгыг алхуулж явсаар Алсын өндөр ууланд гарч...”) гэх мэт. Тодотгол нь зөвхөн тэмдэг нэрээр хязгаарлагдахгүй, орон цагийн нэр, адилтгалаар илэрнэ. Жишээ нь: “галын дөл шиг сэтгэл” - адилтгал тодотгол. Тодотголын орхил нь *Ногооныг авъя* (*Ногоон үзгийг авъя*) гэж нэр үгийг орхиж, тодотголоор нь төлөөлүүлж болох бол *Галын дөл шиг* гэдэг адилтгал нь сэтгэл гэдэг нэр үгийг төлөөлөхгүй байна.

Тодотголын орхил ТҮХШ-д нэр үгийн бүлгийн орхилын нэгэн төрөл бөгөөд өгүүлбэрийн нэр үгийн бүлгийн *юм*, *үзэгдэл* (нэр үг) нь орхигдож, түүний тодотгол буюу чанар, шинж, үнэлэмжийг илэрхийлэх үг дангаар үлдэж, бүхэл нэр үгийн бүлгийг төлөөлөх үзэгдэл юм. М.А.К.Халлидэй, Рукайяа Хасан нар (1976) энэхүү орхилыг “Нэр үгийн орхилд тодотгол нь толгой нэгж болж, юм үзэгдэл буюу нэрлэгдэх зүйл нь нөхцөл байдлаас нөхөгдөнө” гэж тодорхойлсон ба орхил бүлгийн нэр үгийн орхил хэсгийн доторх *нэр үгийг тодотголоор орлох* хэлбэрийн орхил хэмээх дэд төрөлд багтаасан байна. Ийм орхил нь ярианд түгээмэл тохиолдох бөгөөд мэдээллийг давтахгүй байх, өгүүлбэрийг нягт, богино болгох үүрэгтэй юм. Жишээ нь: *Би улааныг авна* гэхэд “улаан (цаас/ даашинз/ хайрцаг)” гэх мэт нөхцөл байдал; *Та томыг ав* гэхэд “том (аяга/ цүнх/ гутал)” гэх мэт нөхцөл байдлаас утга нь нөхөгдөнө. Өгүүлбэрт тодотгуулагчийг орхиход тодотгол нь тодотгуулагчийн үүргээр орох ба уг санааг товч, тодорхой болгох, харилцагчийн хандлага үнэлэмжийг илэрхийлж байна. П.Бямбасан “Монгол хэлний нэр үгийн нэг онцлог” өгүүлэлдээ “Хоёр тавийн боодлын ёотон, тав хорийн өөхтэй хиа” гэх мэт холбоо үгийг бүрэн бүтэн хэлбэл “Хоёр төгрөг тавин мөнгөний үнэтэй боодлын ёотон, таван төгрөг хорин мөнгөний үнэтэй өөхтэй хиа” болох бөгөөд энд “төгрөг”, “мөнгөний”, “үнэтэй” гэсэн үгийг тухай тохиолдолд хэрэглэлгүй орхиж товчилсон байна. Эдгээр үгийг орхиж товчилсны улмаас хэрэглэгдээгүй орхигдсон “мөнгөний” гэсэн харьяалахын тийн ялгалд байсан үгийн тийн ялгалын нөхцөл нь “тавь”, “хорь” гэсэн тооны нэрд шилжин очсоноос “тавь”, “хорь” гэсэн тооны нэр нь харьяалахын тийн ялгалаар хувирч, “төгрөг” гэсэн үг орхигдсон учир үлдсэн “хоёр”, “тавь”, “тав”, “хорь” гэсэн үгс нь орхигдсон үгийнхээ үүргийг өөрийн үүрэгтэй хамт гүйцэтгэн, “хоёр тавийн”, “тав хорийн” гэсэн холбоо үг бүрэлдсэн бөгөөд үүнийг зөвхөн нүдэнд харагдах гадаад шинжээр нь тайлбарлавал уг үзэгдлийн мөн чанарт хавьтахгүйд хүрэх юм. Иймэрхүү зүйлийг зөвхөн гадна талаас нь харж, цаад учрыг нь бодохгүй тайлбарлаж байсан учраас нэг үе тооны нэр, тэмдэг үг бол нэр үгтэй адил тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувирна, нэг нэр үг хоёр өөр тийн ялгалын нөхцөл давхарлан авч “давхар тийн ялгал” үүснэ гэх мэт зүй бус дүрэм тодорхойлолтууд гарч байлаа” (1987: 5-13/ 2006: 223)

гэж өгүүлжээ. Өгүүлбэрийн ил гишүүн-далд гишүүний үүргийг гүйцэтгэж буй тохиолдолд ил гишүүний хэл зүйн хувилал нь далд гишүүнд хамаарна.

М.Базаррагчаа “Өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний синтаксемийн аль нэгээр илэрсэн өгүүлбэрийг тогтворгүй нэг бүрэлдэхүүнт гэсэн бол гол бус синтаксемаар илэрсэн өгүүлбэрийг заримдаг гэж болмоор санагдана. Жишээ нь:

- Чи авсан юм уу?
- Аваагүй /тогтворгүй, нэг бүрэлдэхүүнт, бүрэн бус өгүүлбэр/
- Чи ном авсан уу?
- Юу? /энэ өгүүлбэрт гол гишүүдийн аль нэг нь өнгөн бүтцэд илрээгүй тул

заримдаг өгүүлбэр гэж болно/.

Иймээс онцолсон гишүүн буюу онцолбор нь:

а. Гол синтаксем /гишүүн/-ийн аль нэгээр

б. Гол бус синтаксем, тухайлбал, нэмэн дэлгэрүүлэгч аль нэг гишүүнээр илэрнэ. Жишээ нь: “Чи ямар өнгийг авав” гэхэд “улааныг” гэвэл онцолсон заримдаг өгүүлбэр болно. Дээрхийг дүгнэвэл:

1. Нэг бүрэлдэхүүнт өгүүлбэрийг тогтвортой, тогтворгүй гэж ялган, тогтвортой нэг бүрэлдэхүүнт өгүүлбэрийг гурван зураасаар тэмдэглэж байх нь хялбар оновчтой болмоор байна.

2. Өгүүлбэрийн гол гишүүний аль нэг нь хялбархан сэргэж болох өгүүлбэрийг тогтворгүй, нэг бүрэлдэхүүнт өгүүлбэр гэж болмоор байна. Үүнийг хоёр зураасаар тэмдэглэнэ.

3. Энэ хоёрыг /тогтвортой, тогтворгүй нэг бүрэлдэхүүнт/ бүрэн бус өгүүлбэр гээд өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн нь тодорхой илэрч буй хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэрийг бүрэн өгүүлбэр гэж болох юм.

4. Онцолсон гишүүн нь гол ба гол бус синтаксемийн алинаар ч илрэх ба гол бус синтаксем /тодотгол, байц, тусагдахуун гишүүний аль нэг/-ээр илэрвэл заримдаг өгүүлбэр гэж өнгөн бүтцийн үүднээс ялгаж болно (1986, 16: 34-39/ 2017, 4: 68-69) гээд хэл хэлэх болон хам цуваа цагийн үүднээс, өгүүлбэрийн гол зүйлийг харьцуулан гаргаж, эмхлэн үзэхийн зэрэгцээ уламжлалт хийгээд орчин үеийн хэл шинжлэлийн аль ололттойг зөв хослуулан боловсруулах нь хэлний мэргэжилтэн хүмүүсийн эрхэм зүйл болохыг тайлбарласан байна.

- Бүрэн хэлбэр: *Орчин үеийн барилгууд хуучин барилгаас илүү тухтай.* Орхисон хэлбэр: *Орчин үеийн барилгууд хуучин (Ө)-аас илүү тухтай.* - “барилга” гэдэг үгийн утгыг нь нөхөн ойлгож болно.

- Бүрэн хэлбэр: *Тэр төмөр сандал, модон сандал авсан.* Орхисон хэлбэр: *Тэр төмөр (Ө) ба модон сандал авсан.* - Цөм нэр “сандал” гэдэг үгийн утгыг нь нөхөн ойлгож болно.

- Бүрэн хэлбэр: *Би улаан сарнайд, харин тэр цагаан сарнайд дуртай.* Орхисон хэлбэр: *Би улаан сарнайд, харин тэр цагаан (Ө)-д дуртай.* - “сарнай” гэдэг үгийн утгыг нь нөхөн ойлгож болно. Энэхүү орхил нь тухайн өгүүлбэрийн анхаарлын төвийг чанарын шинж рүү шилжүүлдэг. Өөрөөр хэлбэл, ярьж буй зүйл (барилга, сандал, сарнай гэх мэт) бус, харин түүний чанар, ялгаа анхаарлын төвд ордог ба ихэвчлэн харьцуулал, эсвэл нэг төрлийн гишүүдийг ялгах үүрэгтэй байдаг³.

³ Монгол хэлний тодотгол нь тодотгуулагчдаа утга, байр, үүргээрээ зохицож байдаг ба ямар тодотгол нь тодотгуулагчдаа ойр, ямар нь алсалж байж болох талаар янз бүрийн санал байдаг. Жишээлбэл, *Багшийн хүрэн ширэн хавтастай зузаан хуучин ном ширээн дээр байна* гэхэд *Багшийн, хавтастай,*

Монгол хэлний тэмдэг нэр нь өгүүлбэрт ихэвчлэн үндсээрээ нэрийн тодотгол, үйлийн байдал байц болох боловч *сайныг нь, өндрүүдээс нь* гэх мэтээр тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувилж, бусад гишүүн болох тохиолдол элбэг. Хэлбэрийн энэ шинжид нь тулгуурлаад зарим судлаач тэмдэг нэр нь жинхэнэ нэртэй адил хэл зүйн хувиллаар хувилдаг гэх буюу жинхэнэ нэрээс ялгарахгүй гэж үздэг. Гэтэл ихэнх эрдэмтэн тэмдэг нэр нь хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, үйлийн болц байдлыг нэрлэсэн утгаараа буюу жинхэнэ үүргээрээ байхдаа жинхэнэ нэрийн хувиллаар хувилахгүй харин жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэвэл тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцөл авна гэж тодорхойлж байна (Бямбасан, 1966: 102; 1975: 56; Лувсанвандан, 1961: 225).

ТҮХШ-д *тодотголын орхил*-ыг дээр дурдсан тодотголын үндсэн шинжид тулгуурлан 3 дэд хэсэгт ангилан судалдаг. Үүнд:

1. *Бодит шинжийн орхил*. Жишээ нь: *Минийх шинэ*. – шинэ (шинэ гар утас, шинэ машин, шинэ хувцас гэх мэт).
2. *Үнэлэмжийн орхил*. Жишээ нь: *Би сайхныг авна*. - сайхан (сайхан хүн, сайхан хувцас, сайхан эмээл гэх мэт)
3. *Харьцууллын орхил*. Жишээ нь: *Энэ бол хямд, тэр бол бүр хямдхан*. – хямдхан (үзэг, цамц, цаглавар гэх мэт).

П.Бямбасан “Өгүүлбэрийн доторх үйл үг, нэр үг зэрэг ямар ч аймгийн үгийг хасаж товчлоход хасагдсан үгийн хэл зүйн хэлбэр, агуулга, үүрэг өөр үгэнд шилждэггүй. Өмнөө тодотголтой хэлэгдсэн нэр үгийг орхиж товчлоход хэл зүйн хэлбэр, агуулга, үүрэг нь тодотгож байсан өмнөх үгэнд шилждэг болохоор ямар нэг үг хасаж үгийн тоог цөөрүүлэхээс өөр үзэгдэл юм. Өмнө тодотголтой нэр үгийг орхиж, тодотгож байсан өмнөх үгэнд хавсаргах нь монгол хэлний өөр аймаг үгэнд байхгүй, зөвхөн нэр үгэнд байдаг онцлог шинж мөн бөгөөд орчин цагийн монголын утга зохиолын хэлний хэм хэмжээн дэх үзэгдэл” (1987: 5-13/ 2006: 223-228) гэж тайлбарласан өгүүлбэрт нэр үгийн гүйцэтгэх үүрэг, түүний онцлогийг өгүүлсэн шинэлэг ажиглалт болсон юм. Тодотголын орхил нь *хэмнэх, товчлох* (шаардлагагүй давталтыг багасгах); холбогдох утгыг тодруулах (сонголт, харьцуулалт, сэтгэл хөдлөл, үнэлэмж хандлага илтгэх); бичвэрийн холбоосжилтыг буй болгох (өмнө дурдагдсан объектуудыг дахин нэрлэхгүйгээр үргэлжлүүлэх) үүрэгтэй ажээ.

зузаан, хуучин гэсэн тодотгол ном-д холбогдохдоо бүгд зэрэгцэж байгаа боловч голдуу дараах үгийнхээ шинж чанар болж ойлгогдохгүйг харгалзан аль нь ойр, хол байхыг ялгаж байрлуулдаг. Тодруулбал, *багшийн... ширэн хавтастай* гэдэг нь *зузаан-ы* шинж болохгүй, *багшийн, хүрэн* зэрэг нь *хуучин-ы* шинжээр ойлгогдохгүй. Утга хоёрдуулахгүйн тулд багшийн гэдэг тодотголын байрыг *хавтастай, хуучин, зузаан* гэх мэт тодотголын ард *хавтастай багш, хүрэн ах, ширэн ахын* гэж байрлуулахаас зайлсхийж өмнө нь байрлуулжээ. Өөрөөр хэлбэл, *Багшийн хуучин ном* гэвэл хэний, *ямар, юу?* гэсэн монгол хэлний тогтсон хэллэгийн дэс дараа, хэм хэмжээгээр утга нь бүрэн тодорч байна. Харин *багш, хуучин* гэсэн хоёр нэр үгийн байрыг сольж өөрчлөн, *хуучин багшийн ширээ* гэж болговол *ямар, хэний юу?* гэсэн бүтэцтэй болж *ширээ нь хуучин биш, багш нь хуучин хүн* мэтээр ойлгогдоно. Иймд харьяалахын тийн ялгалт тодотгол нь нэлээд алсалж байдаг. Нэг төрлийн бус зэрэгцсэн тодотголын тухайд, аль болох утга хоёрдуулахгүйн үүднээс байрлалыг шийднэ. Нэг төрлийн зэрэгцсэн тодотгол шиг чөлөөт байрлалтай байж болдоггүй нь дээрхтэй холбоотой юм (Э.Пүрэвжав нар, 2022: 225-226).

Ном зүй

Монгол хэлээр

- Базаррагчаа, М. (2017) Монгол хэлний өгүүлбэр судлал. *Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган*. IV.
- Базаррагчаа, М., нар. (2022) *Өгүүлбэр зүй*. Монгол хэл судлал. XI.
- Баттогтох, Г. (2023) *Орчин цагийн монгол хэлний холбоосын судалгаа*.
- Бямбасан, П. (1987) Монгол хэлний нэр үгийн нэг онцлог. *Хэл зохиол судлал*, XIX.
- Зэнямбуу, Ч., Базаррагчаа, М. (2014) *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*.
- Лувсанвандан, Ш. (1939) *Монгол хэлний зүй*. Улаанбаатар.
- Лувсанвандан, Ш. (1939) Үгүүлбэр хэмээгч юу вэ?, *Шинэ толь*, №1-2, Улаанбаатар, 1939; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*.
- Лувсанвандан, Ш. (1956) *Монгол хэлний зүйн сурах бичиг* (Үгүүлбэрийн зүй); *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 3.
- Лувсанвандан, Ш. (1957) Монгол хэлний нийлмэл үгүүлбэрийн тухай асуудалд. *Багш*, №2, 1957, 15-25; *Багш*, №3, 6-14; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7.
- Лувсанвандан, Ш. (1977) Орчин цагийн монгол хэлний үгэлбэрийн бүтцийг судлах тухай асуудалд. *Хэл зохиол судлал*, XII: 3-33; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7.
- Лувсанвандан, Ш. (1978) Хэлний өнгөн ба гүн бүтцийн тухай асуудалд. *Studia Mongolica*, V(13): 55-60; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7.
- Пүрэвжав, Э., нар. (2022) *Бичгийн хэл*. Монгол хэл судлал. XIII.

Англи хэлээр

- M. A. K. Halliday, & Ruqaiya Hasan. (1976). *Cohesion in English*. Longman.
- M. A. K. Halliday, & Christian M. I. M. Matthiessen. (2014). *Halliday's introduction to functional grammar* (4th ed.). Routledge.
- Geoff Thompson. (2014). *Introducing functional grammar* (3rd ed.). Routledge.
- Eggins, Suzanne. 2004. *An Introduction to Systemic Functional Linguistics* (2nd ed.). Continuum.
- J. R. Martin. (1992). *English text: System and structure*. John Benjamins.
- Margaret Berry. (2012). *Clause as exchange*. Equinox.

Abstract

M.A.K.Halliday and Ruqaiya Hasan studied the system of the cohesion, published 'Cohesion in English', which included substitution, ellipsis, conjunction, and lexical cohesion. Linguists developed within the framework of Systemic Functional Grammar (SFG) theory, also studied the cohesions of languages and are publishing many more research works. According to the theory, it is necessary to study the cohesion of the Mongolian language, and its meaning in the text. We explained examples of nominal ellipsis in Mongolian language.